



**ХЭНТИЙ АЙМГИЙН
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ
УЛСЫН БАЙЦААГЧИЙН ЗӨВЛӨМЖ**

2023 оны 04 сарын 20 өдөр

Дугаар 37/04/01

Хэрлэн сум

Зөвлөмж хүргүүлэх тухай

Монгол Улсын Сангийн сайдын 2023 оны СХШХ/02, Аймгийн Засаг даргын баталсан 37/06/01 дугаартай удирдамжийн дагуу “Төрийн хяналт шалгалтын тухай” хуулийн 5-р зүйлийн 5.1, 5.2-д заасан үндэслэлээр Аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2021, 2022 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд төсөв, санхүүгийн хууль тогтоомж, стандарт, дүрэм журмын хэрэгжилтэнд санхүүгийн баримтанд тулгуурлан хяналт шалгалт хийв.

Хяналт шалгалтаар гарч байгаа зөрчлийг арилгах талаар дараах зөвлөмжийг өгч байна.

1. Анхан шатны баримтыг тамга тэмдэг, гарын үсгээр баталгаажуулах, замын тооцооны хуудасны шатахуун зарцуулалтанд Тээвэр хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалаар баталсан автомашины шатахуун зарцуулалтын нормыг мөрдөж зөрчлийг арилгах;

2. Шилэн дансны тухай хууль, шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийг журмын дагуу тогтмол үнэн зөв мэдээлж ажиллах;

3. Ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх талаар хамтын гэрээнд тусгаж нэг удаа олгох чөлөөний хугацааг тогтоож өгөх, мөн цалин тогтоох, түлээ нүүрсний хөнгөлөлт, унаа хоолны хөнгөлөлт гэх мэт хөдөлмөрийн хууль бусад хуульд заасан хөнгөлөлт тусламжийн хэмжээг тухайн жилийн төсөвт багтаан тогтоож шийдвэрлэж байхаар хамтын гэрээг ажилтнуудын төлөөлөгчид, ажил олгогчийн төлөөлөгчдийн хооронд байгуулах;

4. Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Архив албан хэрэг хөтлөлтийн тухай хуулиудийг мөрдөж данс бүртгэлийг архивын нэгж үүсгэж, жилийн эцсийн тайланд өглөг, авлага үүсгэхгүй ажиллах нь зүйтэй гэж үзлээ.

Энэхүү зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж, шилэн дансанд мэдээлж ажиллахыг байгууллагын дарга, нягтлан бодогч нарт зөвлөж байна.

ЗӨВЛӨМЖ БОЛОВСРУУЛСАН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УЛСЫН
БАЙЦААГЧ, ДОТООД АУДИТОР



С.ЖАВ

232307002



**ХЭНТИЙ АЙМГИЙН
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ
УЛСЫН БАЙЦААГЧИЙН АЛБАН
ШААРДЛАГА**

2023 оны 04 сарын 20 өдөр

Дугаар 37/06/01

Хэрлэн сум

Зөрчил арилгуулах тухай

Төсвийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.16 дахь заалт болон Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ийн дагуу Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2021, 2022 оны санхүү, төсвийн гүйцэтгэл, үйл ажиллагаа, сангуудад хяналт шалгалт хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлаас 22 албан хаагчдад 7005.7 мянган төгрөгний нэг удаагийн буцалтгүй тусламж, 3425.5 мянган төгрөгийг мөнгөн шагналд олгож нийт 10431.2 мянган төгрөгийг зарцуулсан нь тэвчиж болох зардлыг хэмнэж ажиллаагүй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-д “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгохыг хориглоно” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.


Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.9.8-д “хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчлийг таслан зогсоох, түүний шалтгаан нөхцөлийг арилгах талаар холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, иргэн, албан тушаалтанд шаардлага тавьж, хугацаатай үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулах” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2023 оны 06 дугаар сарын 31-ний өдрийн дотор аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанд ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хуулийг хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн даатгалын хэлтсийн дарга Н.Нямхатан, нягтлан бодогч М.Болортуяа нарт даалгав.

3. Илэрсэн зөрчлийг арилгаагүй, хариуг хугацаанд нь ирүүлээгүй тохиолдолд Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн дагуу захиргааны шийтгэл ноогдуулахыг урьдчилан мэдэгдье.

АЛБАН ШААРДЛАГА БИЧСЭН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УЛСЫН
АХЛАХ БАЙЦААГЧ, ДОТООД АУДИТОР  Д.ПҮРЭВЖАВ

ЗӨВШӨӨРСӨН:

ХЭНТИЙ АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

НЯГТЛАН БОДОГЧ

Н.НЯМХАТАН

М.БОЛОРТУЯА





**ХЭНТИЙ АЙМГИЙН
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧИЙН
АКТ**

2023 оны 04 сарын 20 өдөр

Дугаар 37/06/01

Хэрлэн сум

Төлбөр барагдуулах тухай

Төсвийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.16 дахь заалт болон Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ийн дагуу Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2021, 2022 оны санхүү, төсвийн гүйцэтгэл, үйл ажиллагаа, сангуудад хяналт шалгалт хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зарцуулалтыг түүвэрлэн шалгахад тус онуудад 1375.2 мянган төгрөгийг “Санхүү банкны тэргүүний ажилтан” Сангийн яамны “Жуух бичиг”-т дагалдах мөнгөн шагнал олгосон, хүндэтгэл үзүүлж мөнгөн аяга авч зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” Хөдөлмөрийн тухай хуулийн 117 дугаар зүйлийн 117.3-д “ажил олгогч энэ хуульд зааснаас өөр төрлийн олговрыг хамтын гэрээ, хамтын хэлэлцээр, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээгээр тогтоон олгож болно”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3.-д “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгохыг хориглоно” Монгол улсын Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор батлагдсан төрийн алба хаагчид шагнал олгох журмын 1.7-д “төрийн албан хаагчид энэ журамд заасан мөнгөн шагналаас бусад шагнал олгоход мөнгө дагалдахгүй”, Сангийн сайдын 2020 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн дугаар 75 тоот тушаалаар баталсан “Засгийн газрын салбарын тэргүүний ажилтан хүндэт тэмдэг болон Сангийн яамны шагнал олгох журам”-д заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 12 дахь хэсгийн 2-т “аж ахуйн нэгж, байгууллага, иргэний хууль бусаар олсон орлого, эд хөрөнгийг акт үйлдэж улсын орлого болгох, түүнчлэн бусдад учруулсан хохирлыг

232306002

нөхөн төлүүлэх асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх” гэсэн заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Зориулалт бусаар зарцуулсан урамшууллын 1375.2 мянган төгрөгийг Төв төрийн сан дахь улсын төсвийн орлогын 100900000707 тоот дансанд төвлөрүүлэх,


2. Актын биелэлтийг 2023 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлэхийг Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн дарга Н.Нямхатан, нягтлан бодогч М.Болортуяа нарт хариуцуулав.

3. Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ” гэсэн заалтын дагуу дараагийн шатны арга хэмжээ авахыг урьдчилан мэдэгдье.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УЛСЫН
АХЛАХ БАЙЦААГЧ, ДОТООД АУДИТОР  Д.ПҮРЭВЖАВ

ЗӨВШӨӨРСӨН:

ХЭНТИЙ АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ХЭЛТСИЙН ДАРГА  Н.НЯМХАТАН
НЯГТЛАН БОДОГЧ  М.БОЛОРТУЯА



**ХЭНТИЙ АЙМГИЙН
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН
АЛБАНЫ ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ТАНИЛЦУУЛГА**

2023 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 37/04/01

Хэрлэн сум

Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын
хэлтсийн 2021, 2022 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд
хяналт шалгалт хийсэн дүнгийн тухай

Нэг. Хяналт шалгалтын зорилго

1.1. Төсвийн тухай хуулийн 14.2.10, 69 дүгээр зүйлийн 69.3, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 5.2-д заасан үндэслэл, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”, Аймгийн Засаг даргын 2022 оны А/257 дугаар захирамжаар батлагдсан “Санхүүгийн хяналт дотоод аудитын албаны дүрэм”, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Нийгмийн даатгалын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Төсвийн тухай, Шилэн дансны тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай, Хөдөлмөрийн тухай, Төрийн албаны тухай хууль тогтоомж болон тэдгээртэй нийцүүлэн эрх бүхий байгууллагаас баталсан Монгол улсын Засгийн газрын тогтоол, дүрэм журмын биелэлтийг шалгаж хэрэгжилтийг хангуулах, үнэлэлт дүгнэлт өгч, мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр хангах, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, эрсдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор Монгол Улсын Сангийн сайдын 2023 оны СХШХ/02 тоот, Аймгийн Засаг даргын 37/06/01 дугаартай удирдамжийн дагуу ажиллав.

Хоёр. Шалгалтын бүрэлдэхүүн, хугацаа

2.1. Шалгалтыг 2023 оны 03 дугаар сарын 27-ны өдрөөс эхэлж, 20 хоногт багтаан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулалт, хэрэгжилт, өмнөх шалгалтын мөрөөр зохиосон ажил, зөрчил төлбөрийн барагдуулалт, дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа байдал, төсвийн хөрөнгийн зарцуулалт, анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, санхүүгийн тайлан тэнцэл гаргалт, өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, зарцуулалт, хөрөнгийн тооллого, тооцоо бодолт, төсвийн байгууллагад үүссэн өр

авлага, барагдуулалт, тооцоо нийлсэн байдал, удирдлагаас гаргасан шийдвэр нь хууль тогтоомжид нийцсэн эсэхийг хамруулан шалгаж, холбогдох албан тушаалтанд зөвлөгөө өгөх зэргээр Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны даргын үүрэг гүйцэтгэгч, Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч Д.Пүрэвжав, Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч, дотоод аудитор С.Жав, Г.Мөнхболд, Н.Санжаадорж, Б.Оюунтуяа нар хяналт шалгалтыг хийж гүйцэтгэлээ.

Гурав. Шалгалтанд хамрагдсан асуудлууд

3.1. Аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2021, 2022 оны санхүүгийн баримтанд дарга Ц.Баярмаа, Н.Нямхатан, нягтлан бодогч А.Эрдэнэчимэг, М.Болортуяа нар 1, 2 дугаар гарын үсгийг зурж, төсвийн хөрөнгийг захиран зарцуулсан.

3.2. Тус байгууллагын 2020, 2021 оны Сангуудын орлогын төрөл, төвлөрүүлэлт түүний зарцуулалт, үр дүн, нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтын бүрдүүлэлт, бүртгэл хөтлөлт, харилцах, кассаас зарцуулсан мөнгөн хөрөнгийн эрх зүйн үндэслэл, зарцуулалт, үр дүн, тайлан гаргалт, төсвийн санхүүжилт, нэмэлт орлого, байгууллагын батлагдсан орон тоо, ажиллагсдын цалин хөлсний тооцоо бодолт, байгууллагын эд хөрөнгийн бүртгэл, тооллого, тооцоо бодолт, ашиглалт, хадгалалт, хамгаалалтын байдал, өглөг авлагын тооцоо, түүний бүртгэлд үнэн зөв тусгасан эсэх, өр авлагын барагдуулалт, байгууллагын даргын тушаал, дотоод хяналтын төлөвлөгөө, байгууллага, иргэдтэй байгуулсан гэрээний үндэслэл үүргийн хэрэгжилт тайлан зэргийг хамруулан шалгалаа.

Дөрөв. Шалгалтанд хамрагдсан объектын талаарх товч мэдээлэл

4.1. Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс нь анх МҮЭ-ийн Төв Зөвлөлийн Тэргүүлэгчдийн 1942.04.28-ны өдрийн 27-р хуралдааны тогтоолоор тус аймгийн Үйлдвэрчний Эвлэлийн Зөвлөлд Нийгмийг Аюулаас Хамгаалах хэлтэс нэртэйгээр байгуулагдаж нийгмийг аюулаас хамгаалах тухай дүрмийг хэрэгжүүлэн ажиллаж эхэлсэн бөгөөд 1960 оноос Нийгмийн даатгалын хэлтэс болгон зохион байгуулсан байна. Улсын нийгэм хангамжийн ажлыг төвлөрүүлэн зохион байгуулах тухай БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1974 оны 124-р тогтоолыг үндэслэн аймгийн АДХ-ын Гүйцэтгэх Захиргааны 1974.06.24-ний өдрийн 60-р захирамжаар Хөдөлмөр нийгэм хангамжийн хэлтсийг дарга, ня-бо, хөдөлмөрийн байцаагч 1, тэтгэврийн байцаагч 2 бүгд 5 орон тоотой байгуулж байжээ. 1974-1987 онд ХНХ-ийн хэлтэс, 1988-1990 онд Эрүүл мэнд нийгмийн хамгааллын газар, 1991-1994 он дуустал ХНХ-ийн хэлтэс, Монгол улсын засгийн газрын 1994 оны 171-р тогтоолоор

1995 оноос Нийгмийн даатгалын хэлтэс нэртэй болон зохион байгуулагдаж улс орны нийгэм, эдийн засгийн хөгжил, эрхлэх ажил үйлчилгээний өсөлт, хамрах хүрээтэй уялдан нийгэм хангамж, нийгмийн даатгалын албаны 47 орон тооны бүтэц зохион байгуулалтай боловсронгуй болон хөгжсөөр ирсэн байна.

Тав. Өмнөх шалгалтын талаарх мэдээлэл.

5.1. Аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хэнтий аймгийн Аудитын газар 20.8 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байгааг дурдаж зөрчилгүй санал дүгнэлт өгсөн байна.

5.2. 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хэнтий аймгийн Аудитын газар 9 орон тоо дутуу ажиллаж байгаа нь байгууллагын үйл ажиллагаанд хүндрэл учруулсан тухай дурдаж 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд зөрчилгүй санал дүгнэлт өгсөн байна.

Зургаа. Шалгалтын явцад хийгдсэн ажил, шийдвэрлэсэн асуудлууд.

6.1. Шалгалтын удирдамжийг Аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн даргад танилцуулж, Нийгмийн даатгалын сангуудын төрөл, төвлөрүүлэлт түүний зарцуулалт, анхан шатны баримтын бүрдүүлэлт, нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, хөрөнгийн ашиглалт, хадгалалт, байгууллагын удирдлагын шийдвэр, дотоод журмыг үзэж танилцан зөвлөгөө өгч ажиллалаа.

6.1.1 Монгол улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын хавсралт “Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ын дагуу дотоод хяналтын нэгж, ажилтан томилон ажиллуулаагүй, хяналт шалгалтын удирдамж, ажлын төлөвлөгөө гаргаж ажиллаагүй байгаа тул нэгж ажилтан томилон ажиллуулах, ажлын байрны нөхцөл, хууль эрх зүйн актын хэрэгжилтийн талаар сургалт хийж, хяналт шалгалт хийх, бүртгэл хөтлөх талаар;

6.1.2 Байгууллагын бүртгэл санхүүгийн ажилтнуудад тээвэр шатахууны зардал замын тооцооны хуудсанд тээврийн замын ажлыг удирдаж байгаа ажилтнуудаар явсан зам зарцуулсан шатахууны тооцоог хийж гарын үсэг зуруулан баталгаажуулах, Тээвэр хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалаар баталсан автомашины шатахуун зарцуулалтын нормыг мөрдөж ажиллах, машины

тээврийн хэрэгслийн гэрчилгээг замын тооцооны хуудсанд хавсаргаж тооцоо хийж байх, анхан шатны баримтанд тамга тэмдэг дарж баталгаажуулах талаар анхаарч ажиллах;

6.1.3 Нийгмийн даатгалын хэлтсийн төлөөлөгч нь Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2012 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 09 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Орон тооны бус байцаагч ажиллуулах журам”-ын дагуу Нийгмийн даатгалын багц хууль, нийгмийн даатгалтай холбоотой гарсан журам, заавар, нийгмийн даатгалын ажилтны ёс зүйн дүрэм, Сайн дурын даатгалд хамруулах үйл ажиллагаа, Хөдөлмөрийн тухай хууль, хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага, статистик тоо баримтууд, бусад шаардлагатай мэдээллүүдийг заавал хамруулан сургалт зохион байгуулж ажиллахаар ажлын байрны тодорхойлолтонд тусгагдсан байна.

Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн нийгмийн даатгалын төлөөлөгчийн батлагдсан орон тоо-1.

2022 оны 02 сарын 01-ний өдрөөс 2022 оны 4 сарын 30-ний өдрийг дуустал Хэнтий аймгийн хэрлэн сумын 2-р багийн иргэн Б.Энхтуултай, 2022 оны 06 сарын 08-ний өдрөөс 2022 оны 10 сарын 31-ний өдрийг дуустал Хэнтий аймгийн хэрлэн сумын 3-р багийн иргэн Г.Ганцэцэгтэй, 2022 оны 12 сарын 01-ний өдрөөс 2022 оны 12 сарын 31-ний өдрийг дуустал Хэнтий аймгийн хэрлэн сумын 2-р багийн иргэн Л.Цоолоймаатай тус тус 1-3 сарын хөдөлмөрийн гэрээ байгуулан сар бүр 420,0 мянган төгрөгөөр цалинжуулан ажилласан.

Орон тооны бус ажилтан нь иргэдэд E-Mongolia болон Нийгмийн даатгалын аппликейшнуудаас хэрхэн Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагааг авах талаар заавар зөвлөгөө өгч, архивын сан хөмрөгт хадгалагдаж буй баримтуудаас үрэгдэж, элэгдсэн архивын баримтыг нөхөн сэргээж стандартын дагуу засварлан, сумдын байцаагчаас ирүүлсэн архивт хадгалагдах баримтыг тоо ёсоор бүртгэн хариуцагч албан тушаалтан байцаагчид хүлээлгэн өгөх, нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагуу эрхийн харилцаа дуусгавар болж тэтгэвэр нь зогсоогдсон тэтгэвэр авагч иргэдийн тэтгэврийн хувийн хэргийн төрөл, тэтгэвэр тогтоолгосон хуулийн зүйл заалтын дагуу ангилан ялгаж архивын хадгаламжийн төрөл, нэгж болгон цэгцлэн бүртгэдэг байна.

Ажлын тайланг сар бүр бичгээр ирүүлснийг Нийгмийн даатгалын хэлтсийн дарга хянаж баталгаажуулж ажилладаг.

6.2. Санхүүгийн эх үүсвэрийн бүрдүүлэлт, зарцуулалтын талаар

6.2.1. 2021 онд 9.290.026.7 мянган төгрөг улсын төсвөөс, 52216143.6 мянган төгрөг нийгмийн даатгалын сангаас, нийт 61506170.3 мянган төгрөгийн санхүүжилт, 61506170.3 мянган төгрөгийг зарцуулахаар батлуулж, оны эхний үлдэгдэл 6476356.8 мянган төгрөг, улсын төсвөөс 47194.2 мянган төгрөг, нийгмийн даатгалын сангаас 34645231.2 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоос 68351.7 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 364.0 мянган төгрөг нийт 31761141.1 мянган төгрөгний орлого болон санхүүжилт авч, 60908636.6 мянган төгрөг зарцуулж, 6945966.6 мянган төгрөгний харилцахын үлдэгдэлтэй,

2022 оны эхэнд 6945966.5 мянган төгрөгний үлдэгдэл дээр 73262157.0 мянган төгрөг нийгмийн даатгалын сангаас, 9100.9 мянган төгрөг эрүүл мэндийн даатгалын сангаас, 8380248.0 мянган төгрөг улсын төсвөөс санхүүжилт авч нийт 81651505.9 мянган төгрөгийн төсөв батлуулж, 8380248.0 мянган төгрөг улсын төсвөөс, 30334704.5 мянган төгрөг нийгмийн даатгалын сангаас, 94640.7 мянган төгрөг үйл ажиллагааны орлогоос, 156.0 мянган төгрөг туслах үйл ажиллагааны орлогоос нийт 38818850.2 мянган төгрөгний орлого болон санхүүжилт авч, 80955965.6 мянган төгрөгийг захиран зарцуулж, 6263946.4 мянган төгрөгний харилцахын үлдэгдэлийг төвлөрүүлсэн.

6.2.2 Нийгмийн даатгалын хэлтэс нь тэтгэвэр, тэтгэмж, үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчний, ажилгүйдлийн даатгалын сангуудын орлого төвлөрүүлэлт, зарцуулалт хийдэг.

2021 онд 26.965.842.4 мянган төгрөг-ний төлөвлөгөөтэй ажилласан, гүйцэтгэлээр 31.761.141.1 мянган төгрөг сангуудад төвлөрч төсвөөс 31.370.000.0 мянган төгрөг-ийн санхүүжилт авч

* Тэтгэврийн даатгалын сангаас 11828 иргэнд 56.083.928. мянган төгрөг,

* Тэтгэмжийн даатгалын сангаас 4557 иргэнд 2,926,332.7,

* ҮОМШӨ-ний даатгалын сангаас 435 иргэнд 2,830,559.5

* Ажилгүйдлийн даатгалын сангаас 388 иргэнд 840,964.4 мянган төгрөгийн санхүүжилт олгосон бөгөөд сангуудын нийт үлдэгдэл 6,943,585.0 байна,

Нийгмийн даатгалын сан орлогын төлөвлөгөөг 31761141.1 мянган төгрөг буюу 117.8 хувиар биелүүлсэн байна.

2022 онд 32,571.7 сая төгрөгийн төлөвлөгөөтэй ажилласан бөгөөд гүйцэтгэлээр 30,334.7 сая төгрөг сангуудад төвлөрч төсвөөс 44,013,975.6 мянган төгрөгийн санхүүжилтэй.

*Тэтгэврийн даатгалын сангаас 12359 иргэнд 74,951,777 мянган төгрөг,
*Тэтгэмжийн даатгалын сангаас 4531 иргэнд 2,758,079.1 мянган төгрөг,
*ҮОМШӨ-ний даатгалын сангаас 523 иргэнд 4,181,542.0 мянган төгрөг,
*Ажилгүйдлийн даатгалын сангаас 474 иргэнд 1,032,536.8 мянган төгрөгийн санхүүжилт олгосон бөгөөд сангуудын нийт 6,261,864. мянган төгрөг үлдэгдэл төвлөрүүлж ажилласан байна.

Нийгмийн даатгалын сан орлогын төлөвлөгөөг 30334704.6 мянган төгрөг буюу 93.1 хувиар биелүүлсэн байна.

6.3. Үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлт

Санхүүгийн тодруулгын тайланд нийт 283639.6 мянган төгрөгийн барилга байгууламж, орон сууц, нийт 89980.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, машин тоног төхөөрөмжийн дансанд нэмэгдсэн 85832.6 мянган төгрөг үүнээс шилжүүлэн авсан 71494.4 мянган төгрөг бусад 14338.2 мянган төгрөг, хасагдсан 71922.5 мянган төгрөг үүнээс акталсан 1783.2 мянган төгрөг бусад 70139.3 мянган төгрөг нийт 149323.1 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмжийн үлдэгдэлтэй, тавилга эд хогшил дансанд акталсан 1205.0 мянган төгрөг, нийт 67725.5 мянган төгрөгийн тавилга эд хогшил үлдэгдэлтэй, Программ хангамж нийт 7504.5 мянган төгрөг, нийт 20650,0 мянган төгрөгийн газар.

Улсын төсвийн хөрөнгө оруулалт, батлагдсан эх үүсвэрээр бэлтгэсэн, төслийн шугамаар бий болсон хөдлөх хөрөнгө байхгүй.

2021, 2022 ондоо эд хөрөнгийн карт ашиглалтыг жил бүр шинэчлэн хөтлөж ажилласан, мөн хагас бүтэн жилийн тооллогоо хийж, өмч хамгаалах байнгын зөвлөлөөр хэлэлцүүлэн, актлуулах хөрөнгийн хүсэлтийг Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлсэнээр Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын тогтоол ирдэг түүний дагуу хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг хийж ажилладаг.

6.4. Авлага, өглөг

2021 оны санхүүгийн байдлын тайлангаар 5175507.7 мянган төгрөгийн төлбөртэй үйлчилгээний болон татаас санхүүжилтийн авлага мөн 2022 онд 7640840.9 мянган төгрөгийн төлбөртэй үйлчилгээний болон татаас санхүүжилтийн авлага, 83642.8 мянган төгрөгийн өглөг үүссэн үүнийг барагдуулах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан шалгалтанд хамрагдсангүй.

Долоо. Шалгуулагчийн ололттой, дэвшилттэй тал

7.1. Төрийн байгууллагын үйл ажиллагааг тасралтгүй явуулахад анхаарч байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 2021 онд 86.1 хувь, 2022 онд 85.3 хувиар

биелүүлж, сайн дурын даатгуулагчдын хамрагдалтыг өмнөх оны мөн үеэс 32.8 хувиар өсгөсөн байна.

7.2. Аймагтаа 2021 онд төрийн байгууллагуудаас анхны ISO9001:2015 Стандартад нийцсэн чанарын менежментийн тогтолцоог нэвтрүүлж баталгаажуулалтын гэрчилгээг 3 жилийн хугацаатай авсан байна.

Найм. Шалгалтаар илрүүлсэн зөрчил, дутагдал, шалтгаан, түүнээс гарч хариуцагч болзошгүй буюу гарсан хохирол, зөрчигдсөн хууль, тогтоомж, дүрэм, журам, стандартын хэрэгжилт

8.1. 2021 онд Эд хариуцагчийн бараа материалын тайлангийн орлого, зарлага, үлдэгдлийг санхүүгийн тайлантай тулган шалгахад, 66.5 мянган төгрөгийг баримтын бүрдэлгүй зарлагадсан, сэлбэг хэрэгслийн дансанд 170.1 мянган төгрөгийн орлогыг дутуу бүртгэсэн, Харилцахын баримтанд 31745.4 мянган төгрөг, сангуудын төлбөрийн баримтанд 119233.0 мянган төгрөг нийт 150978.4 мянган төгрөгийг анхан шатны баримтын гарын үсэг, тамга тэмдгийн бүрдэл хангалтгүй, нэмэгдсэн өртгийн албан татварын баримт, гэрээ хэлцэл зэрэг анхан шатны баримтын бүрдэл дутуу гүйлгээ хийсэн зэрэг зөрчил байгаа нь НББ-ийн тухай хуулийн 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”;

8.2. Нягтлан бодох бүртгэлийн хөтлөлтийн журналуудыг архивын нэгж үүсгээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д “Аж ахуйн нэгж байгууллага нягтлан бодох бүртгэлийн баримт болон санхүүгийн тайланг Архив албан хэрэг хөтлөлтийн тухай хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол 10-аас доошгүй жил хадгална.”;

8.3. Дотоод хяналтын нэгж томилон ажиллуулаагүй, удирдамж төлөвлөгөө боловсруулан байгууллагын бүхий л үйл ажиллагааг хамруулан хяналт шалгалт хийж холбогдох хууль тогтоомжийн талаар сургалт хийж хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийн бүртгэл мэдээллийн сан бий болгох талаар ажил зохион байгуулаагүй байгаа нь Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ын 1.5-д “Энэхүү журмын 1.4-т зааснаас бусад тохиолдолд “Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам”-ыг тухайн байгууллага, аж ахуйн нэгж өөрөө баталж мөрдөнө.” 3.1-д “Энэхүү журмын 1.3-т заасан “Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам”-д өөрөөр заагаагүй бол дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах үүргийг тухайн

аж ахуйн нэгж, байгууллагын захиргааны асуудал хариуцсан нэгж, ажилтан (цаашид "дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан" гэх) гүйцэтгэнэ", 3.7-д "зохих удирдамж, төлөвлөгөөний дагуу дотоод хяналт шалгалтыг гүйцэтгэж, дүнг тайлагнах"

8.4. Жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар 2021 онд 5175507.7 мянган төгрөгийн авлагын 586423.6 мянган төгрөг нь нийгмийн даатгалын шимтгэлийн авлага, 4521716.9 мянган төгрөг улсын төсвөөс олгосон хөнгөлөлт чөлөөлөлтийн авлага, 2022 онд 7640840.9 мянган төгрөгийн авлагын 3877381.4 мянган төгрөгийн шимтгэлийн авлага, 3704531.1 мянган төгрөгийн хөнгөлөлт чөлөөлөлтийн авлага, 83642.8 мянган төгрөгийн өглөг нь олгогдоогүй тэтгэвэр, тэтгэмж, ажил олгогч, сайн дурын даатгуулагчийн урьдчилж төлсөн шимтгэл тус тус үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж, авлага өр төлбөр үүсгэхгүй байх"

8.5. Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг зөрчин шуудан холбооны зардлаас бичиг хэргийн материал авсан багаж техник хэрэгслийн зардлаас урсгал засварын зардалд шилжүүлсэн, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас орон тооны бус ажилтанд цалин олгосон, шуудан холбооны зардлаас БҮТЭМатериал худалдан авсан, хог хаягдлын зардлаас урсгал засварын материал худалдаж авсан, гэрэл цахилгаан болон цэвэр бохир усны зардлаас урсгал засварын материал худалдаж авсан, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас уралдаан тэмцээний зардалд нийт 6390.2 мянган төгрөг зарцуулсан нь Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар батлагдсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ыг зөрчсөн;

8.6. Цалингийн тооцооны хүснэгт, цагийн баланс, илүү цагийн тооцоо, нэмэгдэл цалин, үр дүнгийн урамшуулал, НДШимтгэл, цалингаас суутгасан татварын тооцоог шалгаж үзэхэд ажилчдын цалингаас хамтын сангийн 10800,0 мянган төгрөгний суутгал хийсэн нь Хөдөлмөрийн тухай хуулийн 119 дүгээр зүйлд "Цалин хөлснөөс хийх суутгал, түүний хэмжээг хязгаарлах";

8.7. Нэг удаагийн буцалтгүй бусад тэтгэмжийн зардлаас тэтгэвэрт гарсан ажилтанд хүндэтгэл үзүүлэх зорилгоор 190,0 мянган төгрөгөөр мөнгөн аяга худалдаж авсан, биеийн тамирын тэргүүн, санхүү банкны тэргүүн, сангийн яамны жуух зэрэг шагналуудад дагалдах мөнгөн шагнал болох 1185,2 мянган төгрөг олгосон нь Монгол улсын сангийн сайдын 2020 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 75 дугаар тушаал "Журам шинэчлэн батлах" тухай Төрийн хэмнэлтийн тухай

хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-д “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгохыг хориглоно” гэснийг тус тус зөрчсөн байна.

Ес. Авсан арга хэмжээ, мэргэжлийн туслалцаа, зөвлөгөө өгсөн байдал:

9.1. Санхүүгийн хяналт шалгалтаар илэрсэн зөрчилд дүгнэлт хийж, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулаж ажиллахыг зөвлөв.

9.2. Тухайн байгууллагад шалгалт хийх хугацаанд Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зарцуулалтыг түүвэрлэн шалгахад тус онуудад 1375.2 мянган төгрөгийг “Санхүү банкны тэргүүний ажилтан” сангийн яамны “жуух бичиг”-т дагалдах мөнгөн шагнал олгосон, хүндэтгэл үзүүлж мөнгөн аяга авч зориулалт бусаар зарцуулсаныг төлбөрийн акт тогтоож.

9.3. Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлаас 22 албан хаагчдад 7005.7 мянган төгрөгний нэг удаагийн буцалтгүй тусламж, 3425.5 мянган төгрөгийг мөнгөн шагналд олгож нийт 10431.2 мянган төгрөгийг зарцуулсан нь тэвчиж болох зардлыг хэмнэж ажиллаагүйг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв

Арав. Шалгагдсан байгууллага, аж ахуйн нэгжид өгсөн дүгнэлт шийдвэрлэвэл зохих асуудал

10.1. Аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2021, 2022 оны санхүү, төсвийн гүйцэтгэл, үйл ажиллагаа сангуудад хяналт шалгалж хийж өглөгө, авлагатай, анхан шатны баримтын бүрдүүлэлт хангалтгүй, эд хариуцагчийн тайлан гаргалт, түүнд тавих хяналт байхгүйгээс эд хариуцагч, нягтлан бодогчийн тайлангууд зөрүүтэй, дотоод хяналт байхгүй зэргээс санхүү, аж ахуйн үйл ажиллагааны “**Бага эрсдэлтэй**” үнэлгээ өгч байна.

Арван нэг. Цаашид авах арга хэмжээний санал

11.1. Шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгах дараах зөвлөмжүүдийг хэрэгжүүлэн ажиллахыг зөвлөж байна

11.2. Анхан шатны баримтын бүрдүүлэлтыг сайжируулж, түүнийг үндэслэн хийх эд хариуцагчийн тайлан тооцоог цаг тухайд нь гаргуулж, уг тайланг үндэслэн бүртгэл хөтлөн санхүүгийн тайлан гаргаж, бүртгэлээрх хяналтыг сайжируулах;;

11.3. Байгууллагын авлага, өглөгийг цаг тухайд нь үнэн зөв тооцон харилцагч иргэн,аж ахуйн нэгж байгууллагатай тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулж ажиллах

11.4. Санхүүгийн байдалын тайлан дахь өр, авлагын тооцоо хийж барагдуулах арга хэмжээ авч ажиллах;

11.5. Хөдөлмөрийн хуулиар хүлээн зөвшөөрснөөс бусад хамтын сангийн суутгалыг ажилтнуудын цалингаас суутган авах асуудлыг таслан зогсоох;


11.6. Хамтын гэрээг байгуулж нэг удаа олгох чөлөөний хугацааг тогтоож өгөх, мөн цалин тогтоох, түлээ нүүрсний хөнгөлөлт, унаа хоолны хөнгөлөлт гэх мэт хөдөлмөрийн хууль бусад хуульд заасан хөнгөлөлт тусламжийн хэмжээг тухайн жилийн төсөвт багтаан хэмжээг тогтоож шийдвэрлэж байхаар хамтын гэрээг ажилтны төлөөлөгчид, ажил олгогчийн төлөөлөгчийн хооронд байгуулах;

11.7. Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар батлагдсан Зардлын эдийн засгийн ангилал ашиглах зааврыг хэрэгжүүлж, төсвийг зориулалтын дагуу зарцуулах;

11.8. Байгууллагын дотоод хяналтын нийтлэг журмын нэгж ажилтан томилон ажиллуулж, журам боловсруулан хяналт шалгалтын төлөвлөгөө гарган удирдамжийн дагуу хяналт шалгалт хийж тайлан гаргаж ажиллах;

ШАЛГАЛТЫН ТАНИЛЦУУЛГА БИЧСЭН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УЛСЫН
БАЙЦААГЧ, ДОТООД АУДИТОР


С.ЖАВ
Г.МӨНХБОЛД
Н.САНЖААДОРЖ
Б.ОЮУНТУЯА

ЗӨВШӨӨРСӨН:

ХЭНТИЙ АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

Н.НЯМХАТАН

НЯГТЛАН БОДОГЧ

М.БОЛОРТУЯА



ТАНИЛЦАЖ, ХЯНАСАН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ,
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УЛСЫН
АХЛАХ БАЙЦААГЧ



Д.ПҮРЭВЖАВ.